**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 11 өдөр Дугаар А/47 Чингис хот

Г.Батгэрэлийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, "Хэнтий-Ус" ХХК-ий Удирдах зөвлөлийн 2013 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Хэнтий-Ус" ХХК-ий дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 2019 оны 01 дүгээр тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гансүхийн Батгэрэл нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн "Хэнтий-Ус" ХХК-ий захирлаар томилсугай.

2. Г.Батгэрэлийн үндсэн цалинг 1400000 /нэг сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр тооцон холбогдох бусад нэмэгдлийг бодож олгохыг "Хэнтий-Ус" ХХК-ий ерөнхий нягтлан бодогч /О.Ундрахбаяр/-д үүрэг болгосугай.

3. Г.Батгэрэлд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

231010900